



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

доЛЗ. 09. 22 № ХТ/до39  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэл Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлштэй холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Засгийн газрын холбогдох гишүүд болон байгууллагаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт <sup>16</sup>... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235020267



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**


Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,  
Цахим шуудан: info@energy.gov.mn

2023.09.15 № а/3064.  
танай 2023.08.21 -ны № ХХ/1941. -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын  
Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгын хариуг  
бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт...**Хуудастай.**





Монгол Улсын Ерөнхий Сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн  
О.Цогтгэрэлийн асуулгад Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд  
хамаарах асуулгын хариу

**2. Утааг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, тэдгээрт зарцуулагдсан төсөв, хөрөнгө оруулалт, татаас болон тэдгээрийн эх үүсвэрийн талаар;**

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд улсын төсвийн 86,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2017-2019 онуудад Улаанбаатар хотын 41964 гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэхээр дамжуулах, түгээх сүлжээнд шинэчлэлтийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн бол 2017-2020 оны түвшинд 228 нам даралтын халаалтын зуухыг зогсоож, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг 43,6 тэрбум төгрөгөөр улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх;

Нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд агаарын чанарыг сайжруулах 1 ба 3-р бүсэд байрлах Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн Таваншарын уулзвараас Дарь-Эх, III, IV дүгээр хороолоос Хайлаастын эцэс хүртэл бүсийг хамарсан 35 хорооны нийт 41964 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах түгээх сүлжээний техникийн боломжийг бүрдүүлэх (нэг өрхөд 4 кВт) барилга угсралтын ажлын 2017-2019 онд хоёр үе шаттай хэрэгжүүлсэн.

д/д	Дүүрэг	I ҮЕ ШАТ		II ҮЕ ШАТ		Нийт хамрагдсан айл өрхийн тоо
		Хороо	Айл өрхийн тоо	Хороо	Айл өрхийн тоо	
1	Баянгол	9, 10, 21, 22, 23	3300	9, 10, 11, 22, 23	4232	7532
2	Сонгинохайрхан	5, 6, 7, 8, 9, 10, 23, 28, 31	8942	7, 8, 11, 23, 28, 30, 31	6491	15433
3	Баянзүрх	2, 21, 27	3732			3732
4	Чингэлтэй	12, 13, 14, 15	2712	7, 8, 9, 10, 11, 12, 16	8864	11576
5	Сүхбаатар	12, 13, 14	2676	7, 9, 11, 12	1015	3691
<b>НИЙТ</b>		<b>24 хороо</b>	<b>21,362</b>	<b>25 хороо</b>	<b>20,602</b>	<b>41,964</b>

Энэхүү ажлын хүрээнд 110 кВ-ын 1 ком дэд станц, 35 кВ-ын 1 ком дэд станц, 10 кВ-ын 3 ком хуваарилах байгууламж, 6-10 кВ-ын 246 ком дэд станцыг шинээр барих, 152 ком дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, 25 фидерийн ачаалал хөнгөлөх, 13 шугамын утасны дамжуулах чадварыг нэмэгдүүлэх, 20602 айл өрхийн оруулгын утас солих, хэрэглэгчийн нэгдсэн тоолуурын хайрцгийг шинэчлэх зэрэг ажлууд хийгдсэн.

Төсөл хэрэгжсэнээр цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэн, сүлжээний горим ажиллагааг оновчтой болгож аваари устгах хугацааг буурч, гэр хорооллын 41964 айл өрхийн цахилгаан хангамж сайжран, 0.4кВ-ын шугамын урт, алдагдал буурч чанартай цахилгаан эрчим хүчээр хэрэглэгчийг ханган, 4.0 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдсэн.

**2. Халаалтын зуухыг зогсоож хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох;**

Агаар орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.9.1-д заасны дагуу 2017-2020 оны түвшинд 228 нам даралтын халаалтын зуухыг зогсоож, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хүрээнд:

Үзүүлэлт	2017 онд	2018 онд	2019 онд	Нийт
Зуухны тоо	45	127	64	236
Барилгын тоо	56	210	70	336
Халаалтын ачаалал Гкал/ц	14.81	26.4	28.4	69.9

2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 236 халаалтын зуухыг зогсоож 336 иргэн аж ахуй нэгжийн барилга объектыг төвлөрсөн дулаан хангамжид холбосон.

**3. Гэр хорооллын айл өрхүүдэд шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлэх;**

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ын хүрээнд агаар, орчны бохирдолтой агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа гэр хорооллын хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тарифт 2017 оноос эхлэн хөнгөлөлт үзүүлж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 317, 318 дугаар "Тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай" тогтоол гарч Нийслэлийн гэр хорооллын хэрэглэгчдийн 21.00-06.00 цагийн хоорондох хэрэглээг 220В-ын хүчдлийн түвшинтэй хэрэглэгчдэд 700 кВт\*ц, 380В-ын хүчдлийн түвшинтэй хэрэглэгчдэд 1500кВт\*ц-ыг 100% хөнгөлж,